


11

Газрыг сэргээж мод тарих

Энэ бүлэгт

Хуудас

Газрын элэгдлээс урьдчилан сэргийлэх	206
Түүх: Төрийн бус байгууллагын ажилтнууд газрын хөрсний элэгдлийн талаар тариаланчдаас суралцсан нь	207
Гэмтсэн газрыг сэргээх нь	208
Байгалийн дэс дараалал	208
Ургамлын үртэй бөмбөлөг яаж хийх вэ?	210
Түүх: Модыг өөрсдөө үржиж ургахад нь тусалсан нь	211
Мод тарих	212
Мод үржүүлгийн газарт мод ургуулах	215
Усан зам болон газрын чийгийг сэргээх	220




Орон нутгийн оршин суугчдын эрүүл мэнд нь цэвэр ус, үржил шимтэй хөрс болон хөрс усыг хамгаалдаг эрүүл моднуудаас хамаарч байдаг. Орон нутгийн оршин суугчдын эрүүл мэндийг хамгаалж сайжруулахын тулд гэмтсэн газрыг яаж сэргээх, газрыг хэрхэн тогтвортой ашиглах арга замыг мэддэг байх ёстой. Газар гэмтэж, мод таслагдаж, хөрс шорооны үржил шимтэй өнгөн хэсэг салхинд хийсч болон усанд туугдаж алдагдсан үед газрыг дахин эрүүл үржил шимтэй болгодог олон аргыг ашиглаж болно.

Газрын элэгдлээс урьдчилан сэргийлэх

Хөрс шорооны алдагдал буюу газрын элэгдэл нь газрын хөрсийг салхи хийсгэх болон ус урсган авч явснаас тохиолддог. Хөрсийг элэгдэхээс хамгаалах нь ялангуяа дов толгод, уулын орой хэсэгт хамгаалалт хийх нь газрыг тариалан тарьж болохуйц үржил шимтэй болгож, газрын бэл хэсэгт орших усны эх сурвалжийг хамгаалан, газар эрэг нурахаас урьдчилан сэргийлнэ. Газрын элэгдлийг хамгаалж, шар усны үерээс хамгаалах гурван зарчмыг тариаланчид мөрддөг.

1. **Уул толгод болон усны ай савын** оройгоос эхлэн байгалийн саад бүтээж, усыг удаашруулах.
2. **Усны суваг шуудуу хийж**, усны тархалтыг олон зүг рүү чиглүүлэн тараах.
3. **Хөрсний чанарыг сайжруулан** усыг шингээж авах чадвартай болгох.

Газрын хөрсний элэгдлийн шинж тэмдгүүдийг танихад хэцүү байх тохиолдол бий. Эдгээр шинж тэмдгүүдийн дотор тариалангийн талбай илүү шаварлаг болох, ургацыг урьдынх шигээ авч чадахгүй алдах, өнгөн хөрс нимгэрэх зэрэг шинж тэмдгүүд байдаг.



Элэгдэл эхлээгүй байхад нь урьдчилан сэргийлж, элэгдэж болзошгүй газруудад мод ургамал аль болох олныг тарьж, борооны усны урсгалыг шуудуу цөөрөм болон байгалийн усан зам болох голууд руу чиглүүлж оруулах зэргээр урьдчилан сэргийлж болно.

Харин газрын элэгдэл их болсон үед элэгдлийг зогсоож, эрүүл хөрсийг сэргээх боломжтой хэвээр байдаг. Уулын уруу газар хөндлөн чиглэлээр чулууг эгнүүлэн тавьж уулын налуу газрыг шууд урсахаас хамгаалахад л хангалттай байдаг бөгөөд чулуунд тогтсон хөрс, үржил шимтэй хэсгүүдэд мод ургамал тарихад тохиромжтой болдог.

Малын баасыг эргүүлэн ашиглах, тариалангийн талбайд тариа ногоог өөрчилж сөөлжүүлж тарих, тариалангийн талбайн дагуу мод тарих, газрын хөрсийг хуурай өвс сүрлээр хучих зэрэг тогтвортой хөдөө аж ахуйн аргууд нь хөрсийг хамгаалж, усны нөөцийг хадгалдаг.

Төрийн бус байгууллагын ажилтнууд газрын хөрсний элэгдлийн талаар тариаланчдаас суралцсан нь

Энэтхэгийн Карнатакагийн Гулбарга мужид нэгэн төрийн бус байгууллага тариалангийн талбай дахь хөрсний элэгдэлтэй тэмцэхээр тариаланчидтай хамтран ажиллажээ. Тариаланчид уулархаг өндөрлөг газруудад өндөр чулуун ханыг хөндлөн босгож хөрсний элэгдлээс хамгаалан, чулуун ханандаа хаалга гаргаж түүгээр их усыг нэвтрүүлдэг байжээ. Төрийн бус байгууллагын ажилтан тариаланчдын барьсан хана тэр чулуунаас доор байгаа



газрын хөрсийг муудахад нөлөөлж байгаа юм биш биз гэж анзаарчээ. Өндөрт өрсөн чулуунуудын зарим нь ус салхинд унаж, чулуунаас доош байгаа газруудад овгор товгор хэсэг үүсгэсэн ба хашилтаас унагасан чулууг нөхөөгүй байжээ.

Төрийн бус байгууллагынхан байгалийн чулуунуудаар биш харин бетонон цутгамал хана хийчихье гэж санаачлав. Тариаланчид “бидэнд чулуу нь хуучнаараа байсан нь дээр, яагаад гэвэл хэдэн чулууг буцааж тавих тийм хэцүү биш” гэжээ. Төрийн бус байгууллагын ажилтан үүнийг ойлгосонгүй.

Тариаланчдын барьсан чулуун хана нь барихад их удаашралтай, тэгээд завсраараа хөрс шороог гаргадаг, тэгээд ч хөрсний элэгдлийг бүрэн зогсоож чадахгүй байгаа юм шиг харагдаж байлаа.

Дараа нь төрийн бус байгууллагынхан туршилт хийе гэжээ. Зарим газраа уламжлалт маягаар чулуугаа тавиад, зарим газраар бетонон хашаа барив. Тариа ногооны бүтэн улирал дууссаны дараа тариаланчид болон төрийн бус байгууллагынхан уулзаж ажлын үр дүнг ярилцжээ.

Цементэн шинэ хашлага тавьсан уулын дор амьдарч байгаа олон тариаланчид ууртай байлаа. Яагаад гэвэл намхан бетонон ханан дээгүүр мал амьтан хялбар давж ирээд тариаланг сүйтгэсэн байна. Бас бороо ороход бетонон ханыг давж ялзмаг ирэхгүй учраас цагаан будааны ургац алджээ. Мөн бетонон хананаас дээш болон доош амьдардаг хүмүүсийн хооронд маргаан гарчээ. Энэхүү туршлага нь тариаланчдын уламжлалт чулуун хананы арга нь шинэ сайжруулсан гэх аргаас хамаагүй дээр юм гэдэг нь нотлогджээ.

Тариаланчид цул бетонон хананаас болж хэтэрхий олон асуудлууд үүссэнийг төрийн бус байгууллагын ажилтнуудад ярив. Энэ туршлагаас үүдэн ТББ-ын ажилтнууд уламжлалт чулуун хаалт нь зөвхөн хөрсний элэгдлээс хамгаалаад зогсохгүй бас үхэр малаас хамгаалдаг гэдгийг мэджээ. Бас зарим хэмжээний хөрс усыг нэвтрүүлж доош алдах нь газрын доор байгаа хөршүүдийн харилцаанд сайнаар нөлөөлж, хүмүүсийн харилцааг муудахаас хамгаалдаг ажээ. Энэ нь чулуу зөөх зэрэг жижиг ажлын дэргэд хамаагүй чухал ашигтай үр дүн байлаа.

Гэмтсэн газрыг сэргээх нь

Заримдаа газар маш их хэмжээгээр гэмтэж, буцааж сэргээн эрүүл байдалд нь оруулах боломжгүй болсон байдаг. Эрүүл газар цөл болон хувирсан юм уу, эсвэл химийн хортой бодис хөрсөнд шингэж, ургамал ургах аргагүй болсон бол ийм газруудыг сэргээхэд хэдэн зуун жил ч хангалтгүй байдаг.

Гэхдээ олон газруудад болгоомжтой ажиллаж, газар нь өөрөө өөрийгөө хэрхэн сэргээдгийг ойлгож чадах юм бол газрыг дахин сэргээж болно. Газрыг хэн ч хүчээр үржил шимтэй болгож чадахгүй. Химийн бордоог газарт тодорхой хугацаанд хэрэглэсний дараа газар түүнийг дахин хүлээн авахаа больдог. Гэхдээ бид байгалийн амьдралын тойргийг анхааралтай ажиглаж чадвал газарт өөрт нь эрүүл үржил шимтэй байхад юу хэрэгтэй байгааг мэдэж авч болно.

Байгалийн дэс дараалал

Заримдаа газрыг сэргээх хамгийн сайн арга нь түүнийг зүгээр зөнд нь орхиж өөрийнхөөрөө бага багаар сэргэхэд нь туслах явдал юм. Газрыг тойруулан хашаа барьж, дээр нь бүү гишгэ гэсэн тэмдэг тавьж, мал сүрэг бэлчээхгүйгээр газрыг хэсэг хамгаалах нь газар сэргэх нэлээд сайн хүчин зүйл юм. Газрыг ашиглахгүйгээр хамгаалснаар тэнд амьдрал эргэн ирж, ургамал эргэн сэргэж, байгалийн орчин нь жам ёсныхоо дэс дараагаар сэргэхэд тусладаг. Энэхүү процесс нь олон жил үргэлжилдэг бөгөөд заримдаа хэдэн үе дамжиж үргэлжилнэ. Байгалийн жамаар нөхөн сэргэх процесс дараах нөхцөлд амжилтгүй болно:


- Ойролцоо газарт нь үр цацах эх үүсвэр байхгүй буюу ойр тойронд нь нутгийн үндсэн ургамал байхгүй бол.
- Ямар нэгэн өөр төрлийн ургамал хэтэрхий их тархаж, үндсэн ургамлуудыг шахан зайлуулсан бол.
- Газар хэтэрхий их бохирдож муудсанаас юу ч ургах боломжгүй болсон бол /нефтийн бүтээгдэхүүн асгарсаны дараа газрыг хэрхэн хамгаалж сэргээх талаар 526-р хуудаснаас үзнэ үү/

Үндсэн ба дагалдах моднууд


Уугуул нутгийн ургамлууд орон нутгийн нөхцөлд хялбархан ургана. Тэд уугуул шавж хорхой, амьтан, шувуудыг татаж орчны биологийн төрөл зүйлийг хадгалдаг.

Заримдаа орон нутгаас гаралтай биш хэрнээ хурдан ургаж сайн түлш болж чаддаг, хөрсийг сайжруулдаг зэрэг ач холбогдолтой моднуудыг тарьж болдог. Зарим шилмүүст болон навчист моднуудыг бүх дэлхий даяараа тарьдаг.


Гэхдээ өөрийн нутагт ургаж байгаагүй шинэ модыг тарих нь заримдаа асуудал бэрхшээлийг үүсгэдэг байна. Жишээлбэл, тэд гүнийн усыг хэтэрхий их хэрэглэж орон нутгийн өвс ургамалтай газрын тэжээл болон усыг татах талаараа өрсөлдөж, хэтэрхий өтгөн шигүү юм уу, хүний хүсээгүй газруудаар ургаж, нутгийн унаган шавж хорхой, амьтдын амьдрах газрыг өөрчилж зугтаалгадаг. Нутгийн үндсэн биш ургамал мод газар нутгийг эзлэх нь газрын хөрсийг байгалийн жамаар нь сэргээх боломжгүй болгодог.




Байгалийн жамаар сэргэх




1. Хөрс нь муудаж ургамалгүй болон муудсан газар.



2. Жижиг хатуу, анхдагч өвснүүд хэмээн нэрлэгддэг эхний өвснүүд хөрсний ус цуглуулж авч чадах хэсгүүд дээр ургана. Анхдагч өвснүүд шавж, шувууг өөртөө татаж эхэлнэ.



3. Хөрсний хагархай, анхдагч өвсний эргэн тойрны ус тогтохуйц газруудад ус хуримтлагдаж тэдгээр хөрсөнд өвсний үр нэмж цацагдана. Шавж шумуулнууд ургамлын үрийг нэмж авчирна.



4. Том өвснүүд болон жижиг моднууд ургаж эхэлнэ. Дагширсан хөрснийг ургамлын үндэс эвдэлж сийрэгжүүлнэ. Газрын хөрс нэмэгдэж, усыг нэмж хуримтлуулах бололцоотой болно.



5. Том өвснүүд болон бут моднууд ургаж газар эргэж сэргэнэ.

Ургамлын үртэй бөмбөлөг яаж хийх вэ?

Эвдэрч муудсан газарт ургамлын амьдралыг сэргээх нэгэн энгийн арга нь үрэн бөмбөлгийг ашиглах явдал юм. Жил бүр зэрлэг ургамлын үр түү. Хүүхдүүд үр түүхдээ маш сайн байдаг бөгөөд энэ нь тэдэнд хөгжилтэй дасгал болдог.

Өөрийнхөө орчноос аль болох олон төрлийн үрийг түүж ир. Эдгээр үрнүүдээс орон нутгийнхаа шороог ашиглан үрэн бөмбөлөг хийнэ. Дараах орцоор холь:

- Нэг орц үр, хоёр орц байгалийн бордоо юм уу хар шороо, гурван орц энгийн шавар шорооноос чулууг нь авах хэрэгтэй.
- Бага зэргийн ус.
- Үрнүүдээ бордоотой юм уу хар шороотойгоо хольж дээрээс нь шавраа нэм.



Дараа нь өчүүхэн бага хэмжээний ус нэмж зөвхөн барьцалдуулах хэмжээнд хүртэл норго. Хэтэрхий их ус нэмбэл үрнүүд хэтэрхий эрт задарч муудна. Энэ хольцоороо жижиг үрэлнүүдийг хий. Дараа нь түүнийгээ хэдэн өдөр наранд хатаа. Борооны улирал эхлэхийн яг өмнө юм уу, эсвэл борооны улирлын үеэр ургамлын амьдралыг сэргээхийг хүсч байгаа тэр газрууддаа үрэлнүүдээ хая.

Эхлээд үрэлнүүдээ хаях газартаа газрыг хонхойлгон шуудуу татаж, бусад байгалийн саадуудыг хий. /296-р хуудсыг үз/ Ингэснээр борооны ус ургамлыг сэргээж байгаа газар руу урсаж тунах, үрийг нахиалж ургахад нь тусална. Үрлээр цацсан үрнүүд бороотой үед л задарч нахиална. Хар шороо болон бордоонууд нь үрэнд хангалттай тэжээл өгч шавар шороо нь түүнийг хатахаас болон хулгана шувуунд идэгдэх буюу салхинд хийсэхээс хамгаална. Жилийн дараа шинэ өвснүүд үрээ цацаж удсан ч үгүй шинэ ургамлууд ургана. Ургамал ургаж байгаа орчинд хөрс шороо бүрэлдэн бий болж элэгдлээс хамгаалагдана. Удалгүй өөр төрлийн өвс ургамал гарч ирнэ.

Хэрэв тэднийг дахин сүйтгэж гишгэлэхгүй бол хэдэн жилийн дараа бүхэл газар нутгаараа ногоорч сэргэнэ.



Модыг өөрсдөө үржиж ургахад нь тусалсан нь

Зүүн Африкийн Сомали улсад хуурай халуун цөлжилтийн цаг агаараас болж цөөхөн мод ургадаг. Тэр цөөхөн моднуудыг түлшинд хэрэглэх гэж тайрснаас улам цөөрчээ. Тэдгээр моднуудын заримыг Сомали хүмүүс хэрэглэсэн боловч ихэнхийг нь өөр оронд худалдахаар авч явжээ.


Гэтэл Фатима Жибрел гэдэг нэгэн эмэгтэй Сомалийн моднуудыг гадаадын оронд худалдахын эсрэг тэмцэл эхлүүлжээ. “Бидэнд мод маань хүрэлцэхтэй үгүйтэй байхад ойн нөөцөө гадаадынханд худалдах бололцоогүй байна” гэж тэр хэлжээ. Фатимагийн кампанит



ажил амжилттай болов. Гэвч кампанит ажил дуусахад маш цөөхөн мод үлдсэн байлаа. Тэгээд тэр Сомали орон даяар шинэ мод ургуулахыг дэмжсэн кампанит ажил эхлүүлжээ. Тэр үгээгүй ядуу болчихоод байгаа хүмүүстээ туслах хамгийн сайн арга нь Сомалид дахин мод ургуулах явдал гэж итгэж байлаа.

Сомалийн газар маш халуун хуурай учир мод тарихад маш хэцүү ажээ. Дээр нь Сомалийн хүмүүс нэг газраас нөгөө газар руу улирал бүр нүүдэг нүүдэлчин хүмүүс учир нэг газраа удаан байж мод арчлах хүн бараг л байхгүй байлаа. Тиймээс Фатима хүмүүст модны эргэн тойронд чулуун хашаа барих аргыг зааж улс орноо тойров.

Газар хэдийгээр тэгшхэн ч гэсэн модыг тойруулан чулуун тойрог баривал түүнийг дагаж амьдрал иргэж ирнэ гэж Фатима итгэж байлаа. Борооны богинохон улиралд энэ жижигхэн хашлагууд хөрсний тэжээлийг цуглуулан барьж ургамал болон модонд өөрсдөө ургах нөхцөлийг нь хангаж байжээ. Одоо Сомали улсад олон жилийн турш байгаагүй олон мод өөрсдөө ургаж байна.



Мод тарих

Зөв нөхцөлд мод тарьснаар гэмтэж эвдэрсэн газрыг сэргээж түлээ түлшний мод, барилгын мод болон хүн амьтанд хоол хүнс, эмийн ургамлыг нь хангаж чаддаг. Мод тарьснаар үржил шимгүй ядуу газрын хөрсийг дахин баялаг үржил шимтэй болгож чаддаг. Гэхдээ хатуу ширүүн уур амьсгалтай газарт модыг сайн ургуулахын тулд арчилгаа хэрэгтэй. Мод тарих нь маш олон ач холбогдолтой бөгөөд гэхдээ бүх газар нутагт бүх орон нутгийнханд ижил тохиромжтой байж чаддаггүй. /197-р хуудасны дасгалыг үзэж мод тарих талаар хэрхэн шийдвэр гаргахыг ажигла. / Мод тарьж ургуулах хэд хэдэн арга бий:

- Модыг үрээр болон үрсэлгээгээр шууд газрын хөрсөнд тарих /213- р хуудсыг үз/
- Зэрлэг үрсэлгээг цуглуулж аван шилжүүлэн суулгах. /214-р хуудсыг үз/
- Модны тарьцыг мод үржүүлгийн газарт ургуулан дараа нь газарт шилжүүлэн суулгах. /215-р хуудсыг үз/
- Тарихыг хүссэн модоо ухан авч өөр модны үндэстэй газарт суулгах. /Энэ аргыг жимсний мод суулгахад ихэвчлэн ашигладаг бөгөөд энэ номонд түүний талаар дурьдаагүй болно/

Та эдгээрийн аль аргаар нь модоо тарихыг шийдэхийн өмнө ямар мод тарихыг хүсч байна, ямар үрсэлгээ тайрдас танд олдох вэ гэдгийгээ тооцож үз.

Үр, тайрдасыг сонгон авах

Ихэнх хүмүүс эх нь ямар байна үр тийм байна гэсэн ойлголттой байдаг. Хүүхдийн ээж, аав нь өндөр бол хүүхэд өндөр болох магадлалтай, түүнтэй нэгэн адил үрийг нь авах гэж буй модыг эцэг, эх гэж хар. Шулуухан ургасан гол мод сайтай модны үрийг авахад сайн мод ургах магадлалтай. Эмийн чанартай модны үрийг цуглуулбал эмийн чанартай ургамал ургана. Хэрэв та өөрийн оршин суугаа газарт модны үр цуглуулж чадахгүй бол ойролцоо хотынхоо үр худалдах газарт буюу мод үржүүлгийн газар очиж модны үр худалдан авч болно.






Мод тарихад зориулж үр бэлтгэх

Зарим үрнүүд ихэвчлэн зөөлөн бүрхүүлтэй, тэжээллэг, шүүслэг байдаг ба тийм үрнүүдийг цуглуулж авангуут тарьж эхлэх ёстой. Зарим үрнүүдийг цуглуулж аваад тарихын өмнө олон сар хадгалах хэрэгтэй байдаг. /Үр хэрхэн хадгалах талаар 309-р хуудаснаас үзнэ үү/

Ихэнх үрнүүдийг задалж соёолуулдаг зүйл нь ус байдаг. Үрийн гадуур хатуу хальс юм уу яс байвал түүнийг зөөлрүүлэх буюу эсвэл зүсэж хагалан ус орох нөхцөлийг бий болгох хэрэгтэй байдаг. Зарим үрийг тарихын өмнө тарилтанд бэлтгэх хэрэгтэй байдаг.

- Хэрэв үрийг бүрхсэн бүрхүүл нь хэтэрхий хатуу бөгөөд зузаан бол түүнийг шууд чийгтэй хөрсөнд суулгаж тарь.
- Хэрэв үрийг бүрхсэн бүрхүүл нь нимгэн бөгөөд хатуу байвал үрийг жижиг даавуугаар боо. Тэгээд түүнийг нэг минут орчим 80 градус орчим халуун усанд барьж дэвтээ. Ус нь буцлаагүй бөгөөд гар хүрэхэд хэтэрхий халуун байх ёстой. Нэг минут орчим халуун усанд дүрсний дараа түүнийг хурдан авч хүйтэн усанд хийгээд шөнөжин дэвтээ. Түүнийгээ маргааш өдөр нь тарь.
- Хатуу хэрнээ нимгэн бүрхүүлтэй үрийг тарихад бэлтгэх бас нэг арга нь үрийг нэг өдөр хүйтэн усанд дэвтээгээд дараа нь нойтон алчуур дотор боож дахин 24 цаг байлгана. Энэхүү процедурыг давтан хийнэ. Долоо дахь өдрөө үрийг тарьж болно.
- Хэрэв бүрхүүл нь хатуу бөгөөд зузаан бол үрийг зүлгүүрээр юм уу хатуу барзгар чулуугаар зүлгэ. Үүнийг хатуу ясны дотор талын зөөлөн хэсэг гарч иртэл нь үргэлжлүүл. Гэхдээ хэтэрхий их зүлгэж үрээ гэмтээхгүй байх ёстой.
- Хэрэв үрийн гадна талын хальс нь зөөлөн хэрнээ зузаан байвал зөөлөн бүрхүүллээс нимгэн хэсгийг зүсч аваад дараа нь дотор талын үрний зөөлөн хэсгээс бага зэрэг зүснэ. Гэхдээ үрний хэсгээс аль болох бага болгоомжтой зүсэх хэрэгтэй.
- Зарим үед хатуу бүрхүүлтэй үрийг бүтэн шөнөжингөө усанд дэвтээхдээ үхрийн аргал усанд хийх нь сайн байдаг. Үүнийхээ дараа наранд нэг өдөр байлгаж хатаана. Энэ процессийг 3-4 өдөр давтана. Ингэхэд сайн үр бол задарч эхлэх бөгөөд тарихад бэлэн болно. Задарч соёолохгүй байгаа үрийг тарихгүйгээр хаяж болно.


Зарим үр их нарийн төвөгтэй аргаар тариалахад бэлэн болдог. Жишээлбэл зарим нь бага гал дээр халаах, эсвэл хөргөх, эсвэл амьтан идэж, амьтны ялгадсаар дамжиж бэлэн болох зэрэг байна. Аль замаар үр нь илүү сайн ургахыг янз янзаар туршиж үз. Хэд хэдэн туршилтын дараа та үрээр мод тарих нарийн мэргэжлийн хүн болж чадна.



Модны тайрдас бэлтгэх

Зарим мод нь модны тайрдасыг хөрсөнд хийж услахад хамгийн сайн ургадаг. Тайрдаснаас ургадаг моднууд нь ихэвчлэн үрээр ургасан модноос илүү үр жимсээ өгч эхэлнэ. Зарим тайрдасыг шууд хөрсөнд суулгаж болдог. Заримыг нь эхлээд мод үржүүлгийн газарт суулгаж задарч нахиалан навч буюу үндэстэй болсных нь дараагаар бие даалган амьдруулж болдог.

Модны тайрдасыг бэлтгэхдээ модны дунд хавийн мөчрийг огтолж бэлтгэнэ. Ингэхдээ модны мөчрөөс 6-10 нахиатай хэсгийг тайрч авна. Тэдгээр нахианаас навч гарч болохуйц байх хэрэгтэй. Модны тайрдасыг авахдаа навч гардаг нахиануудыг гэмтээхгүй байх талаар онцгой анхаар. Мөчрийг тайрч авахдаа тэгш хөндлөн зүсэлгүй хазгай зүсэх хэрэгтэй. Энэ нь үндсийг зөв гарахад тусалдаг. Тайрдасыг мод үржүүлгийн газарт буюу шууд хөрсөнд тарьж байхдаа аль алинд нь сайн усалж байх ёстой бөгөөд тэднийг том мод болж хангалттай үндэстэй болтол нь хортон шавжнаас хамгаалах ёстой.



Шилжүүлэн суулгахыг хүссэн үрсэлгээнүүдийг ойгоос цуглуулж байгаа нь.

Зэрлэг үрсэлгээг шилжүүлэн суулгах

Ой мод үүсгэх бас нэгэн арга нь зэрлэг модны хажуугаас байгалийн жамаараа гарч ирсэн жижиг үрсэлгээнүүдийг ухан авч тэдгээрийг ургуулахыг хүссэн газартаа тарих явдал юм. Эрүүл эцэг, эх модыг олж, түүний ойрхон буюу түүний дор ургасан үрсэлгээнүүдийг олж сонго. Жижиг үрсэлгээг ухан авахдаа том модныхоо гол үндэснүүдийг таслахгүй байхыг анхаар. Тэр үндэснүүд гэмтэх юм бол мод ургахгүй болно. Үрсэлгээнийхээ эргэн тойрны газрыг ухаад том модтой холбогдсон үндэс хаана дуусч байна тэр газар хүртэл ухаж авна.

Үндэсний ойр хавийн шороо ургамлыг хөдөлгөхгүйгээр модыг авахын тулд хуруу болон жижиг багаж ашигла. Үндэстэй хамт гарч ирсэн газрын хөрсийг чийглэг хэвээр нь байлгаж хадгал. Ойгоос авсан үрсэлгээгээ өөр газарт суулгаж тарьтлаа байнга чийгтэй байлгаж усал.

Мод үржүүлгийн газарт мод ургуулах

Мод үржүүлгийн газрууд нь модыг өөр газарт тарихын өмнө эрүүл өсгөж торниулах боломж олгодог. Гэхдээ үржүүлгийн газар байгуулж, нялх моддыг ургуулах нь их ажил шаардана. Дараах тохиолдолд мод тарьж, үрсэлгээ хийх нь ашигтай байдаг:

- Таны тарихыг хүсч байгаа мод, түүний үр тайрдаснууд ховор байгаа бол,
- Залуу моддыг хамгаалахгүйгээс хортон шавж идээд байгаа бол,
- Нялх моддыг арчилж ургуулах хүний тоо хангалттай байгаа бол,
- Модыг үрээр газарт шууд тарих нь хялбар бөгөөд үрсэлгээгээр ургуулахаас хамаагүй амар байдаг. Гэхдээ үрсэлгээнд тарьж ургуулаагүй олон моднууд талбай дээрээ шууд үхдэг учраас эхлээд үрслүүлж өндийлгөх хэрэгтэй.


Модыг хэзээ тарих вэ?

Модыг жилийн аль улиралд хэзээ тарих нь тухайн мод үржүүлгийн аж ахуйд хэр зэрэг удаан байх шаардлагатайгаас хамаарна. Хэрэв танай нутагт чийгтэй болон хуурай улирал гэж байдаг бол чийгтэй улирал эхлэхийн яг өмнө тарь. Ингэвэл та модыг хэтэрхий их услах шаардлагагүй болно. Ихэнх модыг задгай талбайд тарихын өмнө 3-4 сар мод үржүүлгийн газарт тарих шаардлагатай байдаг.

Мод үржүүлгийн талбайг хаана байлгах вэ?

Мод үржүүлгийн газар нь хүрэхэд ойр, усалж арчлахад амар талбайд байх хэрэгтэй. Мөн үрсэлгээний хажууд ажиллаж байгаа хүн бүхэнд аль болох ойр байлгавал зүгээр. Мод үржүүлгийн газар бүрт дараах зүйлс шаардлагатай:


- Усны эх сурвалж ба ус цуглуулж хадгалах газар.
- Багаж тоног төхөөрөмжийг хадгалах агуулах.
- Хөрсийг хольж хутгаж баяжуулах газар.
- Хэт их нар, бороо, салхинаас хамгаалах хамгаалалт.
- Мал амьтан, гадны дайралтаас хамгаалах хашаа.
- Бүх үрсэлгээ, үрэнд хангалттай орон зай.
- Хэрэв уул налуу газарт байгаа бол газрыг тэгшилж тэгш талбай гаргасан байх.



Модны үрсэлгээг саванд ургуулах

Модны үрсэлгээг саванд ургуулах нь тэднийг тарихад хялбар болгоно. Үрсэлгээ ургуулах сав нь модны үрнээс үндэс гарч салбарлах бололцоо олгохуйц хангалттай том байх ёстой бөгөөд гэхдээ бас хэт том байж болохгүй. Хэт том байвал нэгдүгээрт хэтэрхий хүндэрч, хоёрдугаарт модны үрсэлгээнд шаардлагатай хэмжээнээс илүү ус шаардагдана.

Үрсэлгээ нь мод үржүүлгийн газарт удаан байх тусмаа түүнийг хадгалах сав нь том байх ёстой. Ихэнх моднуудын үрсэлгээнд хамгийн тохиромжтой савны хэмжээ нь 15 см өргөн 22 см гүн байдаг.



Сонин, навч, картон зэрэг ялзардаг материалаар хийсэн модны савуудыг мод тарих үедээ шууд газарт үрсэлгээтэйгээ хамт тарина. Харин хуванцар, шил, модон савтай үрсэлгээг савнаас гаргах ба тэдгээр савнуудыг олон удаа ашиглаж болно.

Залуу модны үрсэлгээнүүдийг хэтэрхий халуун нарнаас хамгаалах хэрэгтэй. Ихэнх үрсэлгээнүүд сүүдэрт сайн ургадаг

Мод тарих шороо

Мод тарихад ашигладаг шороо нь сул байх ёстой. Ингэснээр залуу моднууд ялзрахгүй ургана. Бас эдгээр шороо нь тэжээлээр баялаг байх ёстой. /295-р хуудсыг үз/ Ойгоос авчирсан шороо юм уу голын зүлэгнээс авчирсан шороо нь залуу модонд хамгийн тохиромжтой байдаг.



Мод тарих хөрсийг шигшиж байгаа нь

Модны үр юм уу тайрдсыг саванд тарих нь

- 1 Үр тарих шороогоо үр тарихаас нэг өдрийн өмнө усал. Ингэснээр мод тарих өдөр шороо нь чийгтэй боловч их устай биш байна. Үрээ тарихаас өмнө бэлтгэ. Гэхдээ үрийг ялзартал нь удаан бэлтгэх хэрэггүй. Модны савыг хөрс шороогоор дүүргэ.
- 2 Жижиг үрийг тарихын тулд хөрснийхөө өнгөн хэсгийг хуруугаар хонхойлгож 5-10 үр хийгээд түүний дээрээс хөрсөө маш хөнгөхөн сэрээгээр юм уу савхаар хуч. Том үрнүүдийг тарихдаа үрийн өөрийнх нь хэмжээнээс 2-3 дахин гүн байхаар нүхийг савныхаа голд гаргаж үрээ хий. Ингэхдээ нэгээс илүү тооны үр хийх нь зүгээр. Үрээ шороогоор хучиж, шороог хөнгөхөн дарж дагтаршуул. Шороог хөнгөхөн дарж дагтаршуулснаар үрийг тойрсон хий орон зай үүсэхээс хамгаалах бөгөөд тэр орон зайд мөөгөнцөр ургахаас урьдчилан сэргийлнэ.
- 3 Үрээ суулгасны дараа савтай шороогоо усал. Хэрэв жижиг үр суулгасан бол маш бага даралтаар хөнгөхөн услах хэрэгтэй. Эс тэгвэл үр нь угаагдаж алга болно. Үрнээс нэг хоёр навч цухуйж эхэлмэгц үрсэлгээнээс гарч ирж байгаа ишнүүдийг ажиглаж, хамгийн эрүүл сайныг нь сонгож аваад бусдыг нь хайчилж ав. Ингэснээр нэг саванд нэг үрсэлгээ л үлдэнэ. Саванд байгаа илүүдэл үрсэлгээг зулгааж авалгүй хайчилж авснаар та өөрийн ургуулахыг хүсч байгаа үрсэлгээнийхээ үндсийг хамгаалж үлдэнэ.



Модны үрсэлгээг услах

Модны үрсэлгээг услах нь үржүүлгийн аж ахуйн хамгийн чухал ажлын нэг юм. Модыг услахдаа бороо орж байгаа мэт зөөлөн усал. Крантнаас гоожуулж байгаа мэт юм уу, эсвэл хувингаар цутгаж байгаа мэт гэнэт услах нь хөрсийг эвдэлж, үндсийг ил гаргадаг. Үрсэлгээнд ямар хэмжээний ус хэрэгтэй гэдэг нь үрсэлгээний үндэс хэр зэрэг гүн ургаснаас хамаардаг. Үрсэлгээний навч нь булцайж ирсэн бол хангалттай ус авсан гэсэн үг байдаг. Үрсэлгээний навч үрчийж эхэлбэл түүнийг услах цаг боллоо гэсэн үг. Гэхдээ аль болох навчийг үрчийлгэхгүйгээр усалж байх хэрэгтэй. Навч үрчийх бүрт үрсэлгээ ачаалал дарамтанд орсон байдаг. 2-3 навч цухуйж ирэхээс өмнө услахдаа хөрсний өнгөн тал огт хуурай байх тохиолдол бүрт усал. Дараа нь 5-6 навчтай болох үед эрхий хурууныхаа хумсыг хөрсөнд дүрж үзэхэд хөрс хуурай байх юм бол усалж бай. Дараа нь үрсэлгээний үндэс савныхаа хананд тулах хүртэл нь ургасан үед эрхий хурууныхаа эхний үеийг шороонд шигтгэж үзэхэд хөрс хуурай байвал усалж бай.



Хогийн өвс зулгаах ба бордох

Үрсэлгээний моднуудын ойр орчим хогийн өвс ургамал ургаж, ургамалд очих гэрэл, ус, хөрсний шим тэжээлийг уралдан авч байдаг. Саван дотор хэдхэн цөөхөн хогийн ургамал ороход хангалттай хор хохирол учруулдаг. Хэрэв хогийн ургамал ургасан байвал түүнийг угаар нь тайрч ав. Гэхдээ хөрсөө эвдэлж зулгааж авч болохгүй.

Хэрэв хөрс үржил шимтэй бол модны үрсэлгээ өөрт хэрэгтэй шимийг хөрснөөс авч чадна. Харин бордоо хэрэгтэй бол байгалийн бордоог ялгас, ялзмаг болон шээсээр үйлдвэрлэж болно. /15-р бүлгийг үз/

Үрсэлгээг шилжүүлэн суулгах


Үрсэлгээг үрээр тарьж эхэлсний дараа 3-4 сар болоход үндэс нь савныхаа ханыг түлхэж эхэлдэг. Энэ бол шилжүүлэн суулгах цаг болсон гэсэн үг. Хэрэв та модоо шилжүүлэн суулгаж чадахааргүй байвал 7 хоногт нэг удаа үндсийг нь хайчилж бай. Ингэвэл мод бөөрөнхий хэлбэрийн бүтэн үндсийг саван дотроо бүрдүүлж чаддаг бөгөөд ийм үндэстэй үрсэлгээ газарт сайн ургана. Үрсэлгээг шилжүүлэн суулгахаас нэг сарын өмнө үрсэлгээний дээр тавьсан сүүдрэвчийг бага багаар авч задгай газар ирдэг нарны гэрэлд дасга. Ингэснээр үрсэлгээ нь нарлаг хуурай нөхцөлд дасч эхэлнэ. Үрсэлгээг тарихын урьд өдөр савыг нь чийгээр дүүртэл усал. Түүнийг болгоомжтойгоор үндсийг нь гэмтээлгүйгээр зөө. Үрсэлгээ болгоноо хаана тариалахыг хүсч байгаагаа тэмдэглэ.

Мод хоорондын зай нь модны нэр төрлөөс шалтгаална


Модыг тариалсны дараа мод ургаад бие биедээ мөчир навч нь дөнгөж хүрэх зайтай байвал сайн. Үрсэлгээг тариалах орчмын хогийн өвсийг тайрч, үрсэлгээтэй ус хөрсний өрсөлдөөн хийхгүйгээр аюулгүй болго. Ялангуяа үрсэлгээний орчмын нэг метрийн зайд хогийн өвсгүй байлга. Үрсэлгээг суулгахдаа өглөө эрт, эсвэл орой тарьж халуун нарнаас хамгаал. Тарьж байх явцдаа үндсийг хуурайшуулах, гэмтээхээс болгоомжил.




Үрсэлгээний савны өйдрөөс 1,5 дахин гүнзгий дөрвөлжин нүх ух. Бөөрөнхий нүх нь үндэснүүдийг эргэн тойрны хөрснөөс шим тэжээл авахад садаа болдог.



Дөрвөлжин нүхээ шороогоор дүүргэж, дүүрсэн үедээ газрын хөрстэй тэгшхэн байхаар тооцоол. Модныхоо ургалтанд туслахын тулд үрсэлгээнийхээ доор хэдэн атга хар шороо ялзмагийг тавьж өг. Модоо суулгасны дараа эргэн тойрны хөрсийг усал.




Хэцүү газруудад мод тарих



Нялх модыг арчлах

Мод нь эхний нэг жилдээ хамгаалалт арчилгаа их шаардана. Мод тарих ихэнх төслүүд нялх моддыг арчилж чадахгүйгээс болж амжилтгүй болдог. Хэрэв цаг агаар халуун хуурай бол эхний үед модыг өдөр болгон нэг удаа, дараа нь 2-3 өдөр тутамд нэг удаа услах шаардлагатай. Хэдэн долоо хоногийн дараа модны үндэс өөрсдөө усаа олж чаддаг болно.

Гэхдээ цаг агаар хуурай, халуун байвал модыг шаардлагатай үед нь услаад бай. Модоо хогийн ургамлаас өндөр болох хүртэл хогийн ургамлуудыг байнга тайрч бай. Хэрэв амьтан болон хүүхдүүд нялх модыг гэмтээхээд байвал модыг тойруулан хашлага барь. Хэрэв мод сайн ургахгүй, эсвэл навчис нь шар бөгөөд эрүүл бус харагдаж байвал байгалийн бордоог модныхоо мөчрийн диаметртэй тэнцүү өргөнтэйгээр цацах хэрэгтэй. /293-р хуудсыг үз/




Нялх моддыг хамгаалах хашлага хий.

Усан зам болон газрын чийгийг сэргээх

Газрын чийглэг, нойтон байдаг хэсгүүд, голын эргийн нуга, зүлэг зэрэг чийглэг газрууд нь усны ай савд маш чухал үүрэгтэй байдаг. Эдгээр чийглэг газруудад ургадаг ургамал моднууд нь их ач холбогдолтой. Тэд үерийн усыг тогтоож, усыг цэвэрлэж, борооны болон үерийн шар усыг газарт шингэхэд нь тусалж, янз бүрийн амьтан ургамлын амьдралыг тэтгэж байдаг. Хот суурин газруудад гол горхи, усыг шулуун замаар урсахгаар тооцоолж үерийн хамгаалалтын даланг барьсан байдаг. Гэвч голын шулуун урсгал нь усыг хурдан тууж явуулна. Ус хурдан туугдахаараа гол горхийн эрэг орчмын газрыг ширүүн урсгалаараа элээж голын доод хэсэгт үер болгодог аюултай. Үерийн усанд том чулуу, мод гээд том биетүүд урсаж очно. Голын усны доод хэсэгт том том чулуу, мод овоорсон байгааг хараад гол хичнээн хүчтэй үерлэдэг нь мэдэгддэг. Хэрэв голын ус удаан урсадаг гүехэн ч хуурай улиралд том том чулууг голын доод хэсэгтээ ил гаргасан харагдаж байвал энэ нь бороотой улиралд асар хүчтэй үер буудаг гол гэдэг нь танигддаг.




Энэ гол хурдан урсаж, эрэг орчмынхоо газрыг элээн голын доод хэсэгтээ үер буулгах магадлалтай.



Энэ гол удаан урсаж газрын гүнд усыг шингээн авч үлдэх бололцоотой

Ургамлын амьдралыг сэргээх нь

Усны захаар борооны ус зөөлөн тархаж шингэдэг газруудад ургаж буй ногоо, моднууд газрын хөрсийг сайтар тогтоон барьж чаддаг. Гол горхины эрэг орчмын газар хөрсний элэгдэлд орохгүй байх нэг арга нь түүний дагуу мод тарих явдал юм. Голын эргийн хоёр талд 20-50 м-ийн өргөнтэй усархаг талбайд мод, ургамал тарих нь хөрсний элэгдлийг сайн бууруулж чаддаг.



Нойтон үндэстэй байх дуртай моднууд тайрдаснаас хялбархан ургадаг. Тайрдсуудыг хоёр болон түүнээс дээш эгнээгээр тариад тэдгээрийн дундуур жижиг мөчир бутнууд тарь. Энэ нь өөр ургамал амьтанд ирж үүрлэх бололцоо олгон хөрсийг тогтоон барихад тусална. Мод бут, өвснүүд аяндаа өөрсдөө нэмж урган гол горхины ус тогтвортой болно. Мод бут аяндаа ургахгүй бол нэмж тариалж болно. Моджуулсан хэсэг газрыг хүн амьтны хөлөөс хамгаалахын тулд хашаа барьж болно. Мод бүрэн ургасны дараа хашлагыг авч амралт зугаалгын газар болгож болно.



Чийглэг газар болон нугыг хамгаалж сэргээх нь усны ай савыг хамгаалах ажлын чухал хэсэг юм.